

1. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл

“Хөх ган” ХХК нь МУ-ын Бэрэн групп ХХК, Сингапур улсын Фабер инвестмент ХХК-ний хамтарсан хөрөнгө оруулалтаар Монгол улсад анхны ангижруулсан төмрийн үйлдвэрийг бариж ашиглалтанд оруулахаар 2007 онд байгуулагдсан. “Хөх ган” ХХК нь 2007 оноос ангижруулсан төмөрлөгийн үйлдвэрийг барих төслийг хэрэгжүүлж эхэлсэн. “Хөх ган” ХК нь үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Төмөрлөгийн үйлдвэрлэл, гадаад худалдаа билээ.

Энэхүү төслийн зорилго нь жилд 30,000 тонн ангижруулсан төмөр үйлдвэрлэх хүчин чадалтай ангижруулсан төмөрлөгийн үйлдвэрийг Эрдэнэт хотын Говиль багын нутагт барьж байгуулахад оршино.

Төсөл хэрэгжүүлэлтийг дараахь ерөнхий хуваарийн дагуу гүйцэтгэн явуулна.

- Үйлдвэрийн эхний 15,000 тонны хүчин чадалтай шугамыг 2008 оны 6 сард дуусгаж үйл ажиллагааг эхлэх
- Үйлдвэрийн хоёрдугаар 15,000 тонны хүчин чадалтай шугамыг 2008 оны 10 сард дуусгаж үйл ажиллагааг эхлэх
- 2008 онын 12 сарын 1-нээс бүрэн хүчин чадлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Энэхүү үйлдвэр баригдсанаар орчин үеийн технологиор төмрийн баяжмалыг боловсруулж, сайн чанарын ган үйлдвэрлэх шаардлагад тохирох бүтээгдэхүүн гаргах ба ингэснээр эхний ээлжинд уг бүтээгдэхүүнээ экспортлох, цаашидаа Монгол улсад төмөрлөгийн болон гангийн үйлдвэрлэлийг гадны хамгийн сүүлийн үеийн шинэ технологи нэвтрүүлэх замаар дэлхийн хөгжилийн чиг хандлагыг амдан хөгжүүлэхэд чиглэн ажиллаж дотоодын үйлдвэрлэлийн салбарын төмөр болон ган бүтээгдэхүүний эрэлтийг хангах, мөн гадаадын өсч буй эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой болох юм.